



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 10-р цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/114/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2018 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Цэцэгмаа Утас: 70442424 Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn Гэрээт аудитор: Б.Цогзолмаа Утас: 94640011 Цахим хаяг: ttsogzolmaabaterdene@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3.	Аудитлагдсан тайлан	
3.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
3.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
3.3.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
3.4.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
3.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.20 № 2/37.
танай _____-ны № _____-т
Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР СУМЫН ХҮҮХДИЙН
10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.МӨНХТУЯА ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2515050

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1. ОРШИЛ

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Ц.Мөнхтуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.11-нээс 2019.02.15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Б.Цогзолмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн

гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.14-ний өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор сумын 10-р цэцэрлэг нь хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургалтын орчин нөхцөл, сургалтын чанарыг дээшлүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Боловсролын стандартаар сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

байхгүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 46 оноо авсан тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS, PAYRWOLL программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцөлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны Нийт зардал 467,4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 9,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй болно.

2.9. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БАЙХГҮЙ

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд

захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 440,3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 438,7 сая төгрөг буюу 99,6 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 29 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Зөвлөмж өгөөгүй.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор сумын 10-р цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу

материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

3.1. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,987,868.26</u>	<u>43,935,859.40</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	39,987,868.26	43,935,859.40
351	Түүхий эд материал	12,014,467.56	10,958,714.28
35110	Тусгай зориулалттай материал	11,945,687.56	10,884,914.28
35130	Эм боох материал	68,780.00	73,800.00
354	Хангамжийн материал	27,973,400.70	32,977,145.12
35410	Бичиг хэргийн материал	2,733,960.50	3,881,110.50
35420	Аж ахуйн материал	4,617,880.00	7,508,388.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	00.02
35460	Хүнсний материал	156,860.20	1,122,946.60
35470	Бусад хангамжийн материал	20,464,700.00	20,464,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,551,926,618.45</u>	<u>2,116,434,003.80</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,551,926,618.45	2,116,434,003.80
392	Биет хөрөнгө	1,551,902,243.45	1,998,648,253.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,609,288,000.00	1,976,895,452.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,987,600.16	-345,600.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,502,884.00	32,102,884.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,249,423.52	-26,293,717.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,135,439.98	40,135,439.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,630,906.85	-25,690,055.21
39217	Ном	1,843,850.00	1,843,850.00
393	Биет бус хөрөнгө	24,375.00	117,785,750.00
39301	Програм хангамж	450,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-425,625.00	-469,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	117,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,591,914,486.71</u>	<u>2,160,369,863.20</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,591,914,486.71</u>	<u>2,160,369,863.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,591,914,486.71	2,160,369,863.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	139,980,541.08	257,455,541.08
51101	Өмч: - төрийн	139,980,541.08	257,455,541.08
512	Хуримтлагдсан үр дүн	1,451,933,945.63	1,426,623,402.30
51210	Өмнөх үеийн үр дүн	1,451,933,945.63	1,451,933,945.63

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-25,310,543.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	476,290,919.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,591,914,486.71</u>	<u>2,160,369,863.20</u>

3.2. САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	285,967,522.90	442,064,990.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,504,972.90	1,784,290.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	280,462,550.00	440,280,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,382,702.90	21,690.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,382,702.90	21,690.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,122,270.00	1,762,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,122,270.00	1,762,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	284,949,185.49	467,375,533.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,949,185.49	467,375,533.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272,675,012.59	449,153,977.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,845,260.00	220,542,366.33
210101	Үндсэн цалин	131,079,260.00	203,696,981.33
210102	Нэмэгдэл	5,605,500.00	10,625,147.00
210104	Урамшуулал	15,160,500.00	6,220,238.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	23,020,347.67
210201	Тэтгэврийн даатгал	00.00	16,602,286.67
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,793,704.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,250,755.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	245,864.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	3,127,738.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,868,779.00	94,741,946.00
210301	Гэрэл, цахилгаан	2,662,459.00	4,826,460.00
210302	Түлш, халаалт	39,939,648.00	80,569,410.00
210303	Цэвэр, бохир ус	3,266,672.00	9,346,076.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,915,135.12	5,471,692.26
210401	Бичиг хэрэг	911,760.00	411,350.00
210402	Тээвэр, шатахуун	48,720.12	289,999.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	182,335.00	437,064.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	772,320.00	4,333,278.28
2105	Нормативт зардал	46,946,491.50	71,217,593.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,950.00	93,380.00
210502	Хоол, хүнс	46,888,541.50	71,070,213.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	54,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	187,587.00

**Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210604	Урсгал засвар	00.00	187,587.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	673,720.00	850,610.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	673,720.00	850,610.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,425,626.97	33,121,834.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,500.00	864,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	69,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,343,126.97	32,188,534.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,274,172.90	18,221,556.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,274,172.90	16,616,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,122,270.00	1,762,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,382,702.90	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,769,200.00	14,573,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	21,690.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	21,690.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,583,866.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,583,866.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,018,337.41	-25,310,543.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,018,337.41	-25,310,543.33

3.3. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	420,052,498.90	442,064,990.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,566,143.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,566,143.00	00.00
120003	Торгуулийн орлого	11,530.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,554,613.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,554,613.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,486,355.90	442,064,990.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	412,969,200.00	440,280,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,382,702.90	21,690.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,382,702.90	21,690.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,134,453.00	1,762,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,134,453.00	1,762,600.00

Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	420,052,498.90	442,064,990.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,052,498.90	442,064,990.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,320,272.50	423,823,434.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,999,054.00	217,430,324.00
210101	Үндсэн цалин	184,726,354.00	193,770,924.00
210102	Нэмэгдэл	8,991,100.00	10,091,100.00
210104	Урамшуулал	16,281,600.00	13,568,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,726,700.00	26,096,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15,246,700.00	17,364,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,696,100.00	2,183,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,120,000.00	1,746,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	423,900.00	436,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,240,000.00	4,365,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,006,149.00	94,741,946.00
210301	Гэрэл, цахилгаан	4,117,473.00	4,826,460.00
210302	Түлш, халаалт	72,102,676.00	80,569,410.00
210303	Цэвэр, бохир ус	4,786,000.00	9,346,076.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,040,750.00	3,994,364.00
210401	Бичиг хэрэг	399,990.00	311,600.00
210402	Тээвэр, шатахуун	115,920.00	290,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	312,360.00	437,064.00
210404	Ном, хэвлэл	30,000.00	105,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,182,480.00	2,850,300.00
2105	Нормативт зардал	73,071,099.50	74,555,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,400.00	98,400.00
210502	Хоол, хүнс	72,979,699.50	72,036,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,420,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	298,100.00	3,371,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	298,100.00	771,800.00
2107	Томилолт, зочны зардал	48,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	906,720.00	877,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	906,720.00	877,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,223,700.00	2,755,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,088,700.00	2,686,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,135,000.00	69,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,732,226.40	18,241,556.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,732,155.90	16,636,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,134,453.00	1,762,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,445,800.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,382,702.90	00.00

**Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,769,200.00	14,573,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	70.50	21,690.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70.50	21,690.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,583,866.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,583,866.00

3.4. ЦЭВЭР ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,980,541.08	00.00	1,487,136,778.82	00.00	1,627,117,319.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,980,541.08	00.00	1,487,136,778.82	00.00	1,627,117,319.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,634,672.94	00.00	-17,634,672.94
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,980,541.08	00.00	1,451,933,945.63	00.00	1,591,914,486.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,980,541.08	00.00	1,451,933,945.63	00.00	1,591,914,486.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	476,290,919.82	00.00	00.00	476,290,919.82
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	117,475,000.00	00.00	-25,310,543.33	00.00	92,164,456.67
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,455,541.08	476,290,919.82	1,426,623,402.30	00.00	2,160,369,863.20

3.5. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412,969,200.00	412,969,129.50	440,280,700.00	438,696,834.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,969,200.00	412,969,129.50	440,280,700.00	438,696,834.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,754,200.00	398,754,129.5	425,396,500.00	423,823,434.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,443,500.00	208,444,441.00	217,469,900.00	217,430,324.00
210101	Үндсэн цалин	183,170,800.00	183,171,741.00	193,810,500.00	193,770,924.00
210102	Нэмэгдэл	8,991,100.00	8,991,100.00	10,091,100.00	10,091,100.00
210104	Урамшуулал	16,281,600.00	16,281,600.00	13,568,300.00	13,568,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,726,700.00	23,726,700.00	25,807,900.00	26,096,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15,098,800.00	15,246,700.00	17,076,300.00	17,364,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,725,700.00	1,696,100.00	2,183,000.00	2,183,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,157,000.00	2,120,000.00	1,746,200.00	1,746,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	431,300.00	423,900.00	436,500.00	436,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,313,900.00	4,240,000.00	4,365,900.00	4,365,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,006,200.00	8,106,149.00	96,107,400.00	94,741,946.00
210301	Гэрэл, цахилгаан	4,117,500.00	4,117,473.00	3,628,500.00	4,826,460.00
210302	Түлш, халаалт	72,102,700.00	72,102,676.00	82,006,900.00	80,569,410.00
210303	Цэвэр, бохир ус	4,786,000.00	4,786,000.00	10,472,000.00	9,346,076.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,002,600.00	2,029,220.00	4,254,100.00	3,994,364.00
210401	Бичиг хэрэг	338,700.00	388,460.00	289,800.00	311,600.00
210402	Тээвэр, шатахуун	115,900.00	115,920.00	290,000.00	290,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	321,800.00	312,360.00	1,243,600.00	437,064.00
210404	Ном, хэвлэл	62,500.00	30,000.00	105,400.00	105,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,163,700.00	1,182,480.00	2,325,300.00	2,850,300.00
2105	Нормативт зардал	73,071,100.00	73,071,099.50	74,555,000.00	74,555,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,400.00	91,400.00	98,400.00	98,400.00
210502	Хоол, хүнс	72,979,700.00	72,979,699.50	72,036,300.00	72,036,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	2,420,300.00	2,420,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	298,100.00	298,100.00	3,371,800.00	3,371,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	2,600,000.00	2,600,000.00
210604	Урсгал засвар	298,100.00	298,100.00	771,800.00	771,800.00
2107	Томилолт, зочны зардал	48,000.00	48,000.00	196,800.00	00.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	48,000.00	196,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	906,800.00	906,800.00	877,900.00	877,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	906,800.00	906,800.00	877,900.00	877,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,251,200.00	9,251,200.00	2755700.00	2755700.00

**Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,116,200.00	2,088,700.00	2,686,700.00	2,686,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,135,000.00	7,135,000.00	69,000.00	69,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14215000.00	14215000.00	14884200.00	14873400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,215,000.00	14,215,000.00	14,884,200.00	14,873,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,445,800.00	7,445,800.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,769,200.00	6,769,200.00	14,573,400.00	14,573,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	310,800.00	300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	412,969,129.50	00.00	438,696,834.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	412,969,129.50	00.00	438,696,834.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	412,969,129.50	00.00	438,696,834.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	19.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	10.00	10.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	280.00	280.00	226.00	226.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.00	30.00	30.00	30.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	20.00	20.00	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	10.00	10.00